



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 8/74

Хархорин сум

Г Эзэмшил газрын зориулалт  
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Соёмбо хороололын 26 тоотод иргэн Б.Энхтөрийн худалдаа, нийтийн үйлчилгээний газар төв цогцолборын зориулалтаар эзэмшиж байгаа 6209008093 нэгж талбарын дугаартай 1396м<sup>2</sup> газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу үйлчилгээтэй орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2. Газар эзэмшигч Б.Энхтөр-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (Б.Энхтөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

401100347